



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/31/СТА-ТШЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 99890393 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

「БАЯН-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН」
ТӨВИЙН ДАРГА С.ОТГОНЖАРГАЛ
ТАНАА

2020.02.27 № 249

танай _____-ны № _____-г

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020207


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч С.Отгонжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 10-наас 2020 оны 02 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 123 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баян-Овоо сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго: Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг орчин үеийн эмчилгээ оншилогооны стандартад тулгуурлан жигд чанартай хүртээмжтэй хүргэж ажиллахад оршино.

Баян-Овоо сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгэм эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ
- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих гэрийн сувилахуй, сэргээн засах, өдрийн эмчилгээ, оншилгоо эмчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баян-Овоо сумын ЭМТ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Овоо сумын ЭМТ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баян-Овоо сумын ЭМТ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баян-Овоо сумын ЭМТ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнг 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн 267140,8 мянган төгрөгөөс тооцон 5342,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 386138,3 мянган төгрөгөөр тооцон 7722,7 мянган төгрөгөөр тооцож үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22173,8 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,261.6	13,819.8	558.3
33	АВЛАГА	46.8	00.0	-46.8
35	БАРАА МАТЕРИАЛ	13,214.7	13,819.8	605.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	480,347.0	457,614.9	-22,732.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	555,903.1	562,578.5	6,675.4
	Хуримтлагдсан элэгдэл	-75,556.1	-104,963.6	-29,407.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	493,608.6	471,434.7	-22,173.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	489,721.0	471,434.7	-18,286.3
51	Засгийн газрын хувь оролцоо	489,721.0	471,434.7	-18,286.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	493,608.6	471,434.7	-22,173.8

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 605,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь иргэн Х.Энхболд, Р.Ариунзаяа нараас 671,6 мянган төгрөгийн мах хандиваар өгснийг бараа материал орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 6675,4 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь 2019 онд төсвийн хөрөнгөөр 8949,6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан харин 2274,1 мянган төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 12 дугаар тогтоолыг үндэслэн актлан данс бүртгэлээс хассан байна. Тайлант онд 31376,0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон ба хуримтлагдсан элэгдлийн дүн 104963,6 мянган төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 471434,7 мянган төгрөг болж 18286,3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн хасах илэрхийлэгдсэнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баян-Овоо сумын ЭМТ нь төвлөрүүлэх орлого байхгүй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрт зориулан 80101 /үндсэн үйл ажиллагаа/, 81603 /мэргэжлийн тусламж үйлчилгээ/, 80101 /тогтмол зардал/, 80302 /нэг иргэнд ноогдох нормативаар/-д зориулалттай 375873,2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт 376327,2 мянган төгрөгийн зардлын 312040,4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 37258,1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, Эрүүл мэндийн даатгалын сангаас 27028,7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан шалгахад:

Тайлант онд улсын төсвөөс авах 348844,5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, харин ЭМДС-гаас 27028,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 17157,0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлж 9871,7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 365675,3 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь улсын төсвөөс 375873,2 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 326,1 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Сорьц тээврийн зардал 3,7 мянган төгрөг аймгийн Эрүүл мэндийн газраас нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн нь олгогдсон байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэлийг үнэлж гүйцэтгэх үе шатанд 25 эрсдэл тодорхойлж нийт 25 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3979,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 1097,1 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2881,9 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

1. Цалингийн сангийн зардлаас даргын 2019.01.23-ны А/05 тушаалаар 2018 оны байгууллагын аваргын шагналд зориулан Д.Номин-Эрдэнэд 1 сарын үндсэн болох 576.4 мянган төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

2. 2019.04.19-ний өдрийн А/27 тоот тушаалаар "2018 оны Сумын аварга ажилтан"-аар шалгарсан Ё.Доржсэмбэд цалингийн 20% буюу 131,3 мянган төгрөгөөр шагнасан нь төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

3. 2019.06.27-ны өдрийн А/36 тоот тушаалаар Эрүүл мэндийн яамны шагналаар шагнагдсан албан хаагчид шагналын дагалдах мөнгө 389.4 мянган төгрөгийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

1. 2019.03.13-ны өдрийн 2 тоот төлбөрийн хүсэлтээр БИ АЙ ЭМ БИ ХХК-аас 1190.0 мянган төгрөгийн үнэтэй 4 хүний компьютер ширээг урсгал засварын зардлаас худалдан авсан байна.

2. Бараа үйлчилгээний бусад зардлаас "Next electronics"-оос 249.9 мянган төгрөгийн үнэ принтер 2 ширхэг, Баянбардан ХХК-аас 590.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, Ашид мөнх тод ХХК-аас 852.0 мянган төгрөгийн хурдны скайнер худалдан авч хөрөнгө бэлтгэсэн байна

3. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2. батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн

захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2- д “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “ урсгал засварын зардал” гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1097,1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2881,9 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг 2020 оны 04 дүгээр сарын 25-ны дотор нотлох баримтын хамт хариу ирүүлэх.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баян-Овоо сумын ЭМТ-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	32	4	
5	Тухай бүр	8	96	78	18	
	Нийт	27	151	125	24	2

Төсвийн гүйцэтгэл/бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/ мэдээг 1,2-р сард, Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар /улирал бүр/ мэдээг 3-р улиралд, Тухай жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /тухай бүр/ мэдээг 1,2-р сард, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбар /тухай бүр/ мэдээг 1-3 сар, 6-9 саруудад, Байгууллагын батлагдсан төсөв /бүтэн жил/ 1-р улиралд, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концесын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл /бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/ мэдээг 1-р сард, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /тухай бүр/ мэдээг 2-р сард, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /тухай бүр/ мэдээг 1-3-р саруудад, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл /тухай бүр/ мэдээг 2-р сард, Бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр /тухай бүр/ мэдээг 1,2,9-р саруудад, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /тухай бүр/ мэдээг 4-р улиралд, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /тухай бүр/ мэдээг 2-р сард, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /сар бүр/ мэдээг 1-р сард, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн /тухай бүр/ мэдээг 2-р сард тус тус хугацаа хоцроосон байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
Өмнөх аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,261,555.28</u>	<u>13,819,829.17</u>
33	АВЛАГА	46,840.09	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	46,840.09	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,214,715.19	13,819,829.17
354	Хангамжийн материал	13,214,715.19	13,819,829.17
35410	Бичиг хэргийн материал	1,501,820.00	2,145,790.00
35420	Аж ахуйн материал	5,390,684.00	5,656,600.00
35440	Түлш, шатах тослох материал	849,519.74	603,759.17
35460	Хүнсний материал	830,551.45	710,180.00
35470	Бусад хангамжийн материал	4,642,140.00	4,703,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>480,346,998.07</u>	<u>457,614,902.71</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	480,346,998.07	457,614,902.71
392	Биет хөрөнгө	463,154,664.83	440,466,569.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	409,212,162.00	409,212,162.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,901,063.86	-27,063,632.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,100,000.00	35,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,882,198.77	-10,362,198.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,839,571.00	87,653,471.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-58,107,787.16	-61,517,647.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,399,420.30	13,260,925.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,505,438.68	-5,816,510.60
393	Биет бус хөрөнгө	17,192,333.24	17,148,333.20
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-159,666.76	-203,666.80
39303	Бусад биет бус хөрөнгө	16,912,000.00	16,912,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>493,608,553.35</u>	<u>471,434,731.88</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,887,526.42</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,887,526.42	00.00
413	Өглөг	3,887,526.42	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	579,951.42	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,947,575.00	00.00
4136	Бусад өглөг	360,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	360,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>489,721,026.93</u>	<u>471,434,731.88</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	489,721,026.93	471,434,731.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	235,794,363.56	235,794,363.56
51101	Өмч: - төрийн	235,794,363.56	235,794,363.56
512	Хуримтлагдсан үр дүн	-106,996,613.10	-125,282,908.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-106,996,613.10	-106,996,613.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-18,286,295.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	360,923,276.47	360,923,276.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	493,608,553.35	471,434,731.88

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	336,512,390.00	367,852,081.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,255,574.00	1,031,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,255,574.00	1,031,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,255,574.00	1,031,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,255,574.00	1,031,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	298,256,816.00	366,820,481.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	271,182,000.00	311,586,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	271,182,000.00	311,586,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,074,816.00	3,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,074,816.00	3,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	37,258,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	37,258,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	17,972,281.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	815,281.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	17,157,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	309,257,018.12	385,832,724.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	309,257,018.12	385,832,724.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	282,458,143.84	384,432,836.45
2101	Цалин хөлө болон нэмэгдэл урамшил	177,302,370.00	222,247,433.00
210101	Үндсэн цалин	174,515,022.00	221,251,433.00
210102	Нэмэгдэл	00.00	996,000.00
210104	Урамшуулал	2,787,348.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,302,348.91	27,780,929.06
210201	Тэтгэврийн даатгал	13,604,146.36	18,891,030.70
210202	Тэтгэмжийн даатгал	1,700,518.17	2,222,472.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,256,542.76	1,777,979.67
210204	Ажилгүйдлийн даатгал	340,104.23	444,495.17
210205	Эрүүл мэндийн даатгал	3,401,037.38	4,444,950.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,382,577.12	31,338,432.12
210301	Гэрэл, цахилгаан	2,547,683.00	2,466,762.12
210302	Түлш, халаалт	16,714,894.12	28,492,170.00
210303	Цэвэр, бохир ус	120,000.00	379,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,453,257.14	23,790,598.57
210401	Бичиг хэрэг	5,186,680.00	4,590,830.00
210402	Тээвэр, шатахуун	6,793,627.14	10,115,760.57

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,990,850.00	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,482,100.00	7,104,008.00
2105	Нормативт зардал	23,239,657.55	33,450,955.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,988,575.00	26,023,084.00
210502	Хоол, хүнс	5,251,082.55	5,326,871.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,101,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,803,700.00	4,392,000.00
210604	Урсгал засвар	6,803,700.00	4,392,000.00
2107	Томилолт, зочны зардал	783,200.00	1,617,000.00
210702	Дотоод албан томилолт	783,200.00	1,617,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,240.00	80,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-154,660.00	80,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	255,900.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,089,793.12	39,735,488.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,816,350.00	8,359,444.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,273,443.12	31,376,044.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,798,874.28	1,399,888.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,767,416.00	1,070,056.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,070,056.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,767,416.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	27,167.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	27,167.88
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,458.28	302,664.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,458.28	302,664.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	27,255,371.88	-17,980,643.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,050,661.45	305,651.11
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	102,198.77	305,651.11
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	12,948,462.68	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-13,050,661.45	-305,651.11
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	14,204,710.43	-18,286,295.05

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	298,256,816.00	366,820,481.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	298,256,816.00	366,820,481.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	271,182,000.00	311,586,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,074,816.00	3,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,074,816.00	3,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	37,258,100.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	37,258,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	17,972,281.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	815,281.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	17,157,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	298,256,816.00	366,820,481.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	298,256,816.00	366,820,481.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,457,941.72	365,675,367.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,840,653.61	222,818,748.39
210101	Үндсэн цалин	127,098,546.59	167,054,977.62
210102	Нэмэгдэл	29,979,953.41	43,265,735.15
210104	Урамшуулал	13,762,153.61	12,498,035.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,570,639.11	28,357,500.00
210201	Тэтгэврийн даатгал	13,672,200.00	18,940,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,709,000.00	2,354,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,772,747.97	1,883,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	404,139.14	470,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,012,552.00	4,708,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,380,683.00	34,250,932.12
210301	Гэрэл, цахилгаан	2,547,683.00	2,466,762.12
210302	Түлш, халаалт	9,016,000.00	31,392,170.00
210303	Цэвэр, бохир ус	817,000.00	392,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,441,181.00	14,573,850.00
210401	Бичиг хэрэг	550,000.00	977,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,779,991.00	10,007,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	711,850.00	1,992,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,340.00	1,597,050.00
2105	Нормативт зардал	22,053,985.00	30,568,159.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,041,000.00	23,920,659.00
210502	Хоол, хүнс	5,009,985.00	4,637,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,003,000.00	2,010,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,200,000.00	6,885,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,899,700.00	2,505,000.00
210602	Тавилга	00.00	1,400,000.00
210604	Урсгал засвар	5,300,300.00	2,980,000.00
2107	Томиллолт, зочны зардал	783,200.00	1,617,000.00
210702	Дотоод албан томиллолт	783,200.00	1,617,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,965,300.00	5,417,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,828,900.00	5,017,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	136,400.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,222,300.00	21,186,778.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,222,300.00	21,186,778.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,798,874.28	1,145,113.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,767,416.00	815,281.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	815,281.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,767,416.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	27,167.88

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	27,167.88
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,458.28	302,664.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,458.28	302,664.61
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	-106,996,613.10	489,721,026.93
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	-106,996,613.10	489,721,026.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	-106,996,613.10	489,721,026.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,286,295.05	-18,286,295.05
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	-125,282,908.15	471,434,731.88

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	376,327,200.00	365,675,367.51	10,651,832.49	97.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,327,200.00	365,675,367.51	10,651,832.49	97.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	376,327,200.00	365,675,367.51	10,651,832.49	97.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,481,400.00	222,818,748.39	662,651.61	99.70
210101	Үндсэн цалин	168,915,400.00	167,054,977.62	1,860,422.38	98.90
210102	Нэмэгдэл	41,567,100.00	43,265,735.15	-1,698,635.15	104.09
210104	Урамшуулал	12,998,900.00	12,498,035.62	500,864.38	96.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,389,300.00	28,357,500.00	31,800.00	99.89
210201	Тэтгэврийн даатгал	18,996,000.00	18,940,300.00	55,700.00	99.71
210202	Тэтгэмжийн даатгал	2,354,300.00	2,354,300.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,883,400.00	1,883,400.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	447,000.00	470,900.00	-23,900.00	105.35
210205	Эрүүл мэндийн даатгал	4,708,600.00	4,708,600.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,258,100.00	34,250,932.12	7,167.88	99.98
210301	Гэрэл, цахилгаан	4,395,700.00	2,466,762.12	1,928,937.88	56.12
210302	Түлш, халаалт	29,462,400.00	31,392,170.00	-1,929,770.00	106.55
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	392,000.00	8,000.00	98.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,358,400.00	14,573,850.00	784,550.00	94.89
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	977,300.00	222,700.00	81.44
210402	Тээвэр, шатахуун	10,142,400.00	10,007,500.00	134,900.00	98.67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	1,992,000.00	24,000.00	98.81
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,597,050.00	402,950.00	79.85
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	0.00	0.00
2105	Нормативт зардал	31,827,900.00	30,568,159.00	1,259,741.00	96.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,067,900.00	23,920,659.00	147,241.00	99.39
210502	Хоол, хүнс	5,750,000.00	4,637,500.00	1,112,500.00	80.65
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,010,000.00	2,010,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,905,000.00	6,885,000.00	20,000.00	99.71
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,505,000.00	2,505,000.00	0.00	100.00
210602	Тавилга	1,400,000.00	1,400,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,980,000.00	20,000.00	99.33

2107	Томилолт, зочны зардал	1,664,500.00	1,617,000.00	47,500.00	97.15
210702	Дотоод албан томилолт	1,664,500.00	1,617,000.00	47,500.00	97.15
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,967,200.00	5,417,400.00	7,549,800.00	41.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,567,200.00	5,017,400.00	7,549,800.00	39.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	00.00	0.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	0.00	0.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21475400.00	21186778.00	288,622.00	98.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,475,400.00	21,186,778.00	288,622.00	98.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	0.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	00.00	0.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	376,327,200.00	365,675,367.51	10,651,832.49	97.17
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	312,040,400.00	311,287,435.39	752,964.61	99.76
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	312,040,400.00	311,287,435.39	752,964.61	99.76
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,258,100.00	37,230,932.12	27,167.88	99.93
132001	Орон нутгийн төсвөөс	37,258,100.00	37,230,932.12	27,167.88	99.93
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,028,700.00	17,157,000.00	9,871,700.00	63.48
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,028,700.00	17,157,000.00	9,871,700.00	63.48
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх он	Гүйцэтгэл
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	3700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		3700.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3700.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		3700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	3700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3700.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

В. Амаржаргал

П.АМАРЖАРГАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

